



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР

Жуулчны гудамж 5, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 264152, Факс: (976-11) 326611
Цахим шуудан: info@namem.gov.mn
Цахим хуудас: <http://namem.gov.mn/>

2026.04.15 № 01/272

танай _____-ны № _____-т

Г БАЙГАЛЬ ОРЧИН, УУР Г
АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН
ЯАМАНД

Тус агентлаг болон харьяа байгууллагуудын 2026 оны нэгдүгээр улирлын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний үр дүнгийн танилцуулгыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 3 хуудастай.



Цаг уур орчны шинжилгээний газар
Удирдлага
Дарга
Эрхэмбаяр Баттулга
2026-04-15 11:51:57

**ЦАГ, УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
2026 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН БАЙДЛААР ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

2026 оны 04 дүгээр сарын 14-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг: Хяналт шинжилгээний зорилго

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг 2026 оны 1 дүгээр улирлын мэдээнд үнэлэлт дүгнэлт өгөх зорилгоор ажиллав.

Шилэн дансны тухай хуулийг үндэслэн Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтын “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-аар батлагдсан, холбогдох мэдээллийг олон нийтэд мэдээлэн, төсвийн ил тод байдлыг хангах, төсвийн хэрэгжилтэд иргэдээс хяналт тавих нөхцөлийг бий болгож байгаа чухал ач холбогдолтой юм.

Хоёр: Ажлын бүрэлдэхүүн, хугацаа

Шилэн дансны тухай Охууль, “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын хэрэгжилтэд Хяналт, дотоод аудитын хэлтсийн Санхүүгийн дотоод аудит, хяналт шалгалт хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Баасансүрэн 2026 оны 1 дүгээр улирлын мэдээлэлд хяналт хийж ажиллан дүгнэв.

Гурав: Хуулийн хэрэгжилтийн хамрах хүрээ

1. Төсвийн шууд захирагч нар 20 төрлийн мэдээллийг www.shilendans.gov.mn байршуулахаар заасан бөгөөд эдгээр мэдээллийг тайлагнах хугацаа, мэдээллийн агуулгаас хамааран 5 бүлэгт хуваадаг. Үүнд:

- Бүтэн жилээр оруулах мэдээлэл
- Хагас жилээр оруулах мэдээлэл
- Улирал бүр оруулах мэдээлэл
- Сар бүр оруулах мэдээлэл
- Тухай бүр оруулах мэдээлэл

2. Тухайн журмын 8-ийн 8.1-д заасны дагуу шилэн дансанд мэдээлэл тавьсан албан тушаалтан тухайн асуудал хариуцсан нэгж нь байршуулсан мэдээллээ улирал бүр төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албанд дараа сарын 15-ны дотор тайлагнана, мөн 8.2-т дотоод аудитын алба нь улирлын нэгдсэн тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргаан төв байгууллагад дараа сарын 25-ны дотор хүргэх үүрэгтэй.

3. “Шилэн дансны тухай” хуулийн дагуу Цаг, уур орчны шинжилгээний газар нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн 1, төсвийн шууд захирагчийн 25 нийт 26 байгууллагыг хамруулан тус хуулийн хэрэгжилтийг мэдээллийн ангилал тус бүрээр өөрийн цахим хуудас болон www.shilendans.gov.mn сайтад байршуулан иргэд, олон нийтэд мэдээлж байгаад хяналт шинжилгээ хийж зөвлөмж, дүгнэлтийг өгч ажилласан болно.

Дөрөв: Тайлант хугацаанд гүйцэтгэсэн ажлын нэгдсэн тайлангийн үр дүн

Мэдээ оруулсан байдал:

Цаг, уур орчны шинжилгээний газрын 2025 оны 4 дүгээр улирлын “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг байгууллага тус бүрээр www.shilendans.gov.mn сайтаас шүүн ажиллахад төсвийн төвлөрүүлэн захирагчийн/1/, төсвийн шууд захирагч/25/-дын цахим сайтад байршуулах 29 төрлийн 1352 мэдээллийг хугацааны ангиллаар харуулахад дараах байдалтай байна. Үүнд:

Нийт оруулсан нэгдсэн мэдээлэл;

№	Хугацааны ангилал	Байршуулсан мэдээллийн	
		Тоо	Хувь
1	Хугацаандаа оруулсан	1351	99.9
2	Хугацаа хоцорсон	1	0.1
	Мэдээлэл оруулаагүй	0	0
Нийт		1352	
Хуулийн хэрэгжилт		99.9%	

1. Бүх байгууллагын нийт мэдээний 99.9 хувь нь 2026 оны 1 дүгээр улирлын тайланг “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 8.1 заасан хугацаанд буюу дараа сарын 15–аас өмнө байгууллагын нэгдсэн админд цахим хэлбэрээр илгээсэн болно.

2. Шилэн дансны тухай хуулийн дагуу байгууллагын цахим хуудас болон Шилэн дансны нэгдсэн сайтад оруулах мэдээллийг оруулж хэвшсэн бөгөөд 2026 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 1352 мэдээлэл оруулахаас 1351 мэдээллийг хугацаанд нь 1 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан байна.

3. “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилт 2026 оны 1 дүгээр улирлын байдлаар байдлаар нийт 99.9 хувийн хэрэгжилттэй буюу өмнөх улирлаас 0.4 хувь, өмнөх оны мөн үеэс 0.8 хувиар тус тус чанар сайжирсан үзүүлэлттэй гэж дүгнэгдэв.

Тав: Дүгнэлт

5.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 1, төсвийн шууд захирагчийн 25 www.shilendans.gov.mn сайтад байршуулсан мэдээллийн агуулга, хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийхэд хуульд заасан хугацааны дагуу мэдээллээ оруулж байгаа боловч “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын хавсралтад заасан хүснэгтийн дагуу мэдээллээ PDF, XML форматаар цахимаар архивлаж, холбогдох тайлбарыг бүрэн оруулсан нь хуулийн хэрэгжилт өмнөх улирлаас 0.4 хувиар, өмнөх оны мөн үеэс 0.8 хувиар өссөн гэж дүгнэж байна.

5.2 “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилт хугацаа хоцроож мэдээллээ оруулсан, улирлын тайланг дараа сарын 15-аас өмнө хоцроож дүгнэгдсэн байгууллагыг дараах байдлаар харуулав. Үүнд:

5.2.1 Хуулийн хэрэгжилтийн хувь бүүрахад нөлөөлсөн байгууллагууд

- Увс аймгийн Ус, цаг, уур орчны шинжилгээний төв нь 52 мэдээлэл оруулах ёстойгоос 51 мэдээлэл хугацаанд нь оруулж, 1 мэдээллийг хугацаа хоцруулан хэрэгжилт 98.1 хувийн гүйцэтгэлтэй.

Нийтлэг гаргадаг алдаа: Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ гэсэн мэдээг “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2 дэх хэсгийн 3.2.10 дахь заалтад заасны дагуу үнэн зөв мэдээг хавсралтын дагуу оруулдаггүй.

Шилэн дансны тухай” хуулиар хүлээсэн үүргээ хугацаа хоцроож биелүүлсэн Увс аймгийн Ус, цаг, уур орчны шинжилгээний төв нь хугацаандаа мэдээллээ бүрэн гүйцэд оруулж байх шаардлагатай байна.

Зургаа: Зөвлөмж

Төсвийн шууд захирагч болон нягтлан бодогч нарт дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хэвшүүлэх талаар үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтнууд нь хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг сайжруулах, ажлын хариуцлагыг өндөржүүлэн ажиллах;

“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2 дэх хэсгийн 3.2.10. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар; тогтоосон хугацаанд нь нийтэд мэдээлнэ гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 8.1 заалтын дагуу журмын хэрэгжилтийн улирлын тайланг байгууллагын нэгдсэн админд тогтмол илгээж байх;

“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын хавсралтад заасан хүснэгтийн дагуу мэдээллээ PDF, XML форматаар цахимаар архивлаж, холбогдох тайлбарыг бүрэн оруулж шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулж хэвшихийг зөвлөж байна.

Зөвхөн тушаал шийдвэр, гэрээ оруулах, үнэлгээний хорооны тэмдэглэл, зөвлөмж, ирсэн, явсан бичиг, гэрээний төсөл оруулахгүй байх. Илүү оруулсан баримтуудыг хасах, тухай ажлын хүрээнд хийсэн ажлын тайлан, тухайн хувь хүний мэдээлэл, иргэний үнэмлэхийг оруулахгүй байхыг анхаарах шаардлагатай.

Гэрээний хугацаа дууссан эсэхийг анхаарах, гэрээний хугацаа дууссан бол хугацааг сунгах, гэрээг дахин байгуулж оруулах шаардлагатай. Үнэлгээний хорооны тэмдэглэл, зөвлөмж, ирсэн явсан бичиг оруулахгүй байх.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд улирал бүр дотоод аудит хяналт шинжилгээ хийдэг гэдгийг шинээр тухайн байгууллагад орж, ажиллаж байгаа холбогдох албан хаагч, нягтлан бодогчдод хэлж, мэдээллээ хуулийн хугацаанд үнэн зөв бодитоор /долоо хоног, сар, улирал, хагас, бүтэн жил/ тогтмол оруулж хэвшихийг үүрэг болгох;

-----o0o-----

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАРЫН 2026 ОНЫ 1 УЛИРЛЫН ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

№	Байгууллага	Төсөв/гүйцэтгэл				Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт				Бусад				Дүн				Хувь		
		Нийт	Хугацаан даа оруулсан	Хугацаа хоцорсон	мэдээлэл оруулаагүй	Нийт	Хугацаан даа оруулсан	Хугацаа хоцорсон	мэдээлэл оруулаагүй	Нийт	Хугацаан даа оруулсан	Хугацаа хоцорсон	мэдээлэл оруулаагүй	нийт	Хугацаан даа оруулсан	Хугацаа хоцорсон	нийт	Хугацаан даа оруулсан	Хугацаа хоцорсон	
1	Цаг, уур орчны шинжилгээний газар	22	22	0	0	12	12	0	0	18	18	0	0	52	52	0	0	100.0	100.0	0.0
2	Архангай УЦУОШГ	22	22	0	0	12	12	0	0	18	18	0	0	52	52	0	0	100.0	100.0	0.0
3	Баян-Өлгий УЦУОШГ	22	22	0	0	12	12	0	0	18	18	0	0	52	52	0	0	100.0	100.0	0.0
4	Баянхонгор УЦУОШГ	22	22	0	0	12	12	0	0	18	18	0	0	52	52	0	0	100.0	100.0	0.0
5	Булган УЦУОШГ	22	22	0	0	12	12	0	0	18	18	0	0	52	52	0	0	100.0	100.0	0.0
6	Говь-Алтай УЦУОШГ	22	22	0	0	12	12	0	0	18	18	0	0	52	52	0	0	100.0	100.0	0.0
7	Дорноговь УЦУОШГ	22	22	0	0	12	12	0	0	18	18	0	0	52	52	0	0	100.0	100.0	0.0
8	Дорнод УЦУОШГ	22	22	0	0	12	12	0	0	18	18	0	0	52	52	0	0	100.0	100.0	0.0
9	Дундговь УЦУОШГ	22	22	0	0	12	12	0	0	18	18	0	0	52	52	0	0	100.0	100.0	0.0
10	Завхан УЦУОШГ	22	22	0	0	12	12	0	0	18	18	0	0	52	52	0	0	100.0	100.0	0.0
11	Өвөрхангай УЦУОШГ	22	22	0	0	12	12	0	0	18	18	0	0	52	52	0	0	100.0	100.0	0.0
12	Өмнөговь УЦУОШГ	22	22	0	0	12	12	0	0	18	18	0	0	52	52	0	0	100.0	100.0	0.0
13	Сүхбаатар УЦУОШГ	22	22	0	0	12	12	0	0	18	18	0	0	52	52	0	0	100.0	100.0	0.0
14	Сэлэнгэ УЦУОШГ	22	22	0	0	12	12	0	0	18	18	0	0	52	52	0	0	100.0	100.0	0.0
15	Төв УЦУОШГ	22	22	0	0	12	12	0	0	18	18	0	0	52	52	0	0	100.0	100.0	0.0
16	Увс УЦУОШГ	22	21	1	0	12	12	0	0	18	18	0	0	52	51	1	0	100.0	98.1	1.9
17	Ховд УЦУОШГ	22	22	0	0	12	12	0	0	18	18	0	0	52	52	0	0	100.0	100.0	0.0
18	Хөвсгөл УЦУОШГ	22	22	0	0	12	12	0	0	18	18	0	0	52	52	0	0	100.0	100.0	0.0
19	Хэнтий УЦУОШГ	22	22	0	0	12	12	0	0	18	18	0	0	52	52	0	0	100.0	100.0	0.0
20	Дархан-Уул УЦУОШГ	22	22	0	0	12	12	0	0	18	18	0	0	52	52	0	0	100.0	100.0	0.0
21	Орхон УЦУОШГ	22	22	0	0	12	12	0	0	18	18	0	0	52	52	0	0	100.0	100.0	0.0
22	Говьсүмбэр УЦУОШГ	22	22	0	0	12	12	0	0	18	18	0	0	52	52	0	0	100.0	100.0	0.0
23	Байгаль орчин хэмжил зүйн төв лаборатори	22	22	0	0	12	12	0	0	18	18	0	0	52	52	0	0	100.0	100.0	0.0
24	Улаанбар хотын УЦУОШГ	22	22	0	0	12	12	0	0	18	18	0	0	52	52	0	0	100.0	100.0	0.0
25	Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэн	22	22	0	0	12	12	0	0	18	18	0	0	52	52	0	0	100.0	100.0	0.0
26	Нислэгийн цаг уурын төв	22	22	0	0	12	12	0	0	18	18	0	0	52	52	0	0	100.0	100.0	0.0
	нийт дүн	572	571	1	0	312	312	0	0	468	468	0	0	1352	1351	1	0	100.0	99.9	0.1
	хувиар	100.00	99.8	0.2	0.0	100.0	100.0	0.0	0.0	100.0	100.0	0.0	#DIV/0!	100.0	99.9	0.1	0.0	100.0	99.9	0.1

